

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газар

Албан тушаалын нэр:

Төвийн дарга

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Нийгмийн эрүүл мэндийн төв

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-7

Ажлын байрны албан ёсны байршил:

Хэнтий аймаг, Хэрлэн сум, 4-р баг

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй


### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Эрүүл мэндийн салбарын болон бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, Халдварт бус өвчний сэргийлэлт, хяналт хоол тэжээл хүнсний аюулгүй байдал болон сэтгэцийн эрүүл мэнд, донтох эмгэг тэдгээрийн нийтлэг эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх хянах арга хэмжээг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүргийн хэрэгжүүлж, нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг Эрүүл мэндийн газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт


- 1.Эрүүл мэндийн салбарын болон бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хянах, тайлагнах;
- 2.Халдварт бус өвчний сэргийлэлт, хяналт хоол тэжээл хүнсний аюулгүй байдал болон сэтгэцийн эрүүл мэнд, донтох эмгэг тэдгээрийн нийтлэг эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх, хянах, бууруулахад чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулахад мэргэжил арга зүйгээр хангах, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах;
- 3.Төвийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах;
- 4.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм журам, стандартыг хэрэгжүүлэх.

| Зорилт                    | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг                                                                                                                                                                                                                                                                                                 | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт                                            | Хариуцлага оролцооны хэлбэр<br>Туслах – Т,<br>Хариуцан гүйцэтгэх – Г<br>Хянах – Х<br>Шийдвэрлэх–Ш |
|---------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Халдварт бус өвчнөөс сэргийлэх, эрт илрүүлэх, хянах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;                                                                                                                                                                              | Халдварт бус өвчний эрт илрүүлэг, хяналт сайжирна.                       | Г,Х                                                                                               |
|                           | 2. Халдварт бус өвчний хяналт, урьдчилан сэргийлэлтийн чиглэлээр олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах, үндэсний хөтөлбөр, стратегитай уялдуулах, тайлагнах үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангах;                                                                    | Хөтөлбөр, стратегийн хэрэгжилт хангагдана.                               | Г,Х                                                                                               |
|                           | 3. Хүн амд эрүүл, зохистой хооллох зан үйлийг төлөвшүүлэх, хоол тэжээлийн байдлыг сайжруулах, хоол тэжээлтэй холбоотой эмгэгээс урьдчилан сэргийлэх талаар орон нутгийн онцлог хэрэгцээнд тохирсон бодлого, үйл ажиллагааг төлөвлөх, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах, хяналт тавих, | Орон нутгийн онцлогт тохирсон бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт хангагдана. | Г,Х                                                                                               |






|  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |                                                                    |  |     |
|--|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------|--|-----|
|  | зүйгээр хангаж ажиллах;                                                                                                                                                                                                                                                                                                                                        |                                                                    |  |     |
|  | 2.Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг жигд хүртээмжтэй тасралтгүй явуулахад шаардлагатай арга хэмжээг бусад холбогдох байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулах;                                                                                                                                                         | Эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалт нэмэгдэнэ.                      |  | Г   |
|  | 3.Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах арга хэмжээг харьяа эрүүл мэндийн байгууллагуудад үр дүнтэй зохион байгуулахад мэргэшил аргагүйн зөвлөгөө өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;                                                                                                                                                                              | Эрүүл мэндийн байгууллагын чадавхи сайжирна.                       |  | Г,Х |
|  | 4.Халдварт бус өвчин, сэтгэцийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, хоол тэжээлээс үүдэлтэй эмгэгээс сэргийлэх талаарх иргэд, олон нийтийн хандлагыг дээшлүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, арга зүйн дэмжлэг үзүүлэх;                                                                                     | Иргэд, олон нийтийн мэдлэг, хандлага сайжирна.                     |  | Г   |
|  | 5. Халдварт бус өвчин, сэтгэцийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, хоол тэжээлээс үүдэлтэй эмгэгээс сэргийлэх чиглэлээр сургалт явуулах эмч, арга зүйч, сайн дурын идэвхтэнд зориулсан сургалтын хөтөлбөр, гарын авлага, удирдамж боловсруулан сургалт зохион байгуулах, тэдний мэдлэг, заах ур чадварыг дээшлүүлэх, арга зүйгээр хангаж ажиллах; | Эмч, арга зүйч, сайн дурын идэвхитнүүдийн мэдлэг, чадвар дээшилнэ. |  | Г   |
|  | 6.Бага насны хүүхдийн хоол тэжээлийн талаарх мэдээ, тайлан гаргах, тайлангийн чанарыг сайжруулах;                                                                                                                                                                                                                                                              | Тайлагналт сайжирна.                                               |  | Г,Х |



|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |                                                                                             |     |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------|-----|
| 7.Халдварт бус өвчин, сэтгэцийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, хоол тэжээлээс үүдэлтэй эмгэгээс сэргийлэх чиглэлээр нөлөөллийн ажилд хэвлэл мэдээллийн байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах;                                                                                                                                             | Нөлөөллийн арга хэмжээнд хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоо, хамтын ажиллагаа сайжирна. | Г   |
| 8. Сургууль, цэцэрлэгийн "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, бүх шатны боловсролын байгууллагад хоол, хүнсний зохистой хэрэглээний "Ногоон жор" хөдөлгөөн өрнүүлэх;                                                                                                                                                                                                                                   | Ногоон жор хөдөлгөөний хэрэгжилт хангагдана.                                                | Г,Х |
| 9.Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний байдалд үнэлгээ өгөх, үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах;                                                                                                                                                                                                                                                                              | Эрүүл мэндийн байгууллагын хоол үйлдвэрлэлийн хяналт сайжирна.                              | Г,Х |
| 10.Эмнэлэг, сувилалын газруудын хоолны чанар, тэжээллэг байдалд хяналт тавьж арга зүйн зөвлөгөө өгч ажиллах;                                                                                                                                                                                                                                                                                                        | Эмчлүүлэгч, сувиулагчид тэжээллэг чанартай хоолоор хангагдана.                              | Г,Х |
| 11.Зөв зохистой хооллох, хоол тэжээлийн байдлыг сайжруулах, хоол тэжээлтэй холбоотой эмгэгээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагаанд бусад салбарын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах, хамтрагч байгууллагуудын дунд мэдээлэл солилцох албан бус сүлжээ байгуулан ажиллах, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах, үр дүнг тооцох; | Салбар хоорондын уялдаа холбоо, мэдээлэл солилцоо сайжирна.                                 | Г   |
| 12.Сэтгэцийн эмгэгээс сэргийлэх, хянах талаар бусад салбар, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор хамтарсан төлөвлөгөө боловсруулах, арга зүйгээр хангаж                                                                                                                                                                      | Төрийн болон төрийн бус байгууллага, салбар хоорондын хамтын ажиллагаа хангагдана.          |     |



|                                             |                                                                                                                                                                                                                     |                                                                   |  |   |
|---------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------|--|---|
|                                             | хамтран ажиллах.                                                                                                                                                                                                    |                                                                   |  |   |
| 3 дугаар зорилтын хүрээнд                   | 1. Төвийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган, мэргэжилтнүүдийг мэргэжлийн арга зүй, зөвлөмжөөр хангаж, дадлагажуулах замаар төрийн үйлчилгээний стандартыг мөрдүүлэх, харилцааны соёл, хандлагыг сайжруулах. | Мэргэжилтнүүд чадавхжиж, төрийн үйлчилгээний стандарт хангагдана. |  | Г |
| 4 дүгээр зорилтын хүрээнд                   | 1.Төрийн албаны стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах;                                                                                                                                     | Ёс зүйн зөрчил гаргасан эсэх.                                     |  | Г |
|                                             | 2. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;                                             | Ашиг сонирхлын зөрчил гаргасан эсэх.                              |  | Г |
|                                             | 3.Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;                                                                                          | Хэрэгжилтийн хувь.                                                |  | Г |
|                                             | 4.Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг гүйцэтгэх, эргэн мэдээлэх;                                                                                                                                             | Биелэлтийн хувь.                                                  |  | Г |
|                                             | 5.Байгууллага, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, биелэлтийг тайлагнах;                                                                                                                        | Хэрэгжилтийн хувь.                                                |  | Г |
|                                             | 6.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах;                                                                                                                | Хэрэгжилтийн хувь.                                                |  | Г |
|                                             | 7.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.                                                                                                                                                            | Хэрэгжилтийн хувь.                                                |  | Г |
| III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА |                                                                                                                                                                                                                     |                                                                   |  |   |
| Боловсрол                                   | Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.                                                                                                                                                              |                                                                   |  |   |

|           |                                                                                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
|-----------|-----------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Мэргэжил  | Анагаах ухаан /0912/, Нийгмийн эрүүл мэнд /0918/                                                    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
| Мэргэшил  | Төрийн албаны мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх.                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
| Туршлага  | Дэс түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил эсхүл төрийн албанд 4-өөс доошгүй жил ажилласан байх. |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
| Ур чадвар | Удирдан зохион байгуулах                                                                            | <ul style="list-style-type: none"> <li>- Хариуцсан ажлаа төлөвлөх, зохион байгуулах;</li> <li>- Албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилж, удирдан зохион байгуулах;</li> <li>- Албан хаагчдын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, өдөр тутмын удирдлагаар хангах;</li> <li>- Хариуцсан нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэж, шаардлага тавьж чаддаг байх;</li> <li>- Бусад.</li> </ul>                                                                                                |
|           | Дүн шинжилгээ хийх                                                                                  | <ul style="list-style-type: none"> <li>- Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх, нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах;</li> <li>- Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;</li> <li>- Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх;</li> <li>- Тоон мэдээлэлтэй ажиллах, нэгтгэн дүгнэх, статистикийн арга хэрэгслийг ашиглах чадвартай байх;</li> <li>- Бусад.</li> </ul>                                                                             |
|           | Асуудал шийдвэрлэх                                                                                  | <ul style="list-style-type: none"> <li>- Үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх;</li> <li>- Хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах;</li> <li>- Шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх;</li> <li>- Аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх;</li> <li>- Хууль, эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх;</li> <li>- Бүтээлч, санаачилгатай ажиллах;</li> <li>- Бусад.</li> </ul> |
|           | Манлайлах                                                                                           | <ul style="list-style-type: none"> <li>- Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх;</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |

|  |       |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
|--|-------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|  |       | <ul style="list-style-type: none"> <li>- Багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх;</li> <li>- Багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах;</li> <li>- Үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>- Хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх;</li> <li>- Нээлттэй шударга байх;</li> <li>- Бусад.</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
|  | Бусад | <ul style="list-style-type: none"> <li>- Өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх;</li> <li>- Зарчимч, тууштай, ажил хэрэгч байх;</li> <li>- Шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх;</li> <li>- Хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх;</li> <li>- Албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх;</li> <li>- Компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;</li> <li>- Төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх;</li> <li>- Англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх.</li> </ul> |

#### IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ


Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:  
Эрүүл мэндийн газрын дарга

|                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
|--------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</p> <p>Мэргэжилтнүүд - 7</p> | <p>Бусад харилцах субъект:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн байгууллагуудын дарга нар;</li> <li>- Эмнэлгийн ажилчид;</li> <li>- Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын холбогдох ажилтан;</li> <li>- Эрүүл мэндийн яамны холбогдох мэргэжилтэн;</li> <li>- Эрүүл мэндийн хөгжлийн төвийн холбогдох мэргэжилтэнүүд;</li> <li>- Иргэн, хуулийн этгээд, төрийн бус байгууллагын холбогдох ажилтан.</li> </ul> |
|--------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

#### V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ



|                                                                                                                                                                                                                                                      |                                                                                        |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------|
| Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:                                                                                                                                                                                                         | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:    |
| Албан тушаал:<br>ЭДИЙН ЗАСАГ, УДИРДЛАГА<br>ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА<br>Д.БААСАНДОРЖ<br>20... оны ... дугаар сарын ... -ны өдөр                                                                                                                    | Байгууллагын нэр:<br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br>Шийдвэрийн огноо: 19 11 04<br>Дугаар: 278 |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:                                                                                                                                                                                                              |                                                                                        |
| Байгууллагын нэр:<br>ХЭНТИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР<br>Шийдвэрийн огноо: .....<br>Дугаар: .....<br>ДАРГА  Ц.ГЭРЭЛМАА<br>20... оны ... дугаар сарын ... -ны өдөр |                                                                                        |



-----oOo-----